



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хар нуур Ховд голын сав газрын захиргааны 2022 оны санхүүгийн тайланд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/22/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: С.Оюунжаргал

Утас: 99911390

Цахим хаяг: Oyunjargais@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

|   |    |
|---|----|
| <b>1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....  | 3  |
| <b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....   | 4  |
| <b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....   | 10 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....   | 10 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....   | 11 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....   | 11 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....  | 11 |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....  | 12 |
| <b>3.5.1 Төсвийн төлөвлөлт</b> .....  | 12 |
| <b>3.5.2 Төсвийн гүйцэтгэл</b> .....  | 12 |
| Гүйцэтгэлээр улсын төсвөөс 148,522.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна .....  | 12 |
| <b>3.5.3 Нэмэлт төсөв</b> .....   | 12 |
| <b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....  | 13 |
| <b>4.1 Ерөнхий зүйл</b> .....   | 13 |
| <b>4.2 Материаллаг байдал</b> .....   | 13 |
| Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 191.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 2.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2.3 сая төгрөгөөр тогтоосон ..... | 13 |
| <b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....  | 13 |
| <b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> .....   | 13 |
| <b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....   | 14 |
| 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....   | 14 |
| <b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....   | 14 |
| <b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....   | 15 |

**Товчилсон үгийн жагсаалт**

|          |   |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт               |
| БОАЖЯ    | Байгаль орчин аялал жуулчлалын яам                          |
| МУ       | Монгол улс  |



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

ХАР НУУР ХОВД ГОЛЫН САВ ГАЗРЫН  
ЗАХИРГААНЫ ДАРГА Р.ЭНХСҮРЭН ТАНАА

2023.02.28 № 02/54  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### ӨӨРЧЛӨЛТГҮЙ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хар нуур ховд голын сав газрын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хар нуур Ховд голын сав газрын захиргааны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Дэлхийн байгаль хамгаалах сангаас Жаргалант сумын нутаг дэвсгэр болон Буянт гол дагуу газарт камержуулалт, бусад тоног төхөөрөмж авахад 40.7 сая төгрөг, мөн сургалтын зардалд 31.3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж хамтран ажилласан байна.

#### Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

#### Бусад асуудлын хэсэг

БОАЖЯ-ны сайдтай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын баримт бичигт тусгагдсан 11 зорилтын 32 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжилт 91.7 хувьтай үнэлэгдсэн байна.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

021020278

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



*X. Болдбаатар*

Х.БОЛДБААТАР

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт                                  | Эхний үлдэгдэл       | Эцсийн үлдэгдэл      |
|------------|--|----------------------|----------------------|
| <b>1</b>   | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>                     | <b>4,605,850.00</b>  | <b>46,332,100.00</b> |
| <b>35</b>  | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>                              | 4,605,850.00         | 46,332,100.00        |
| <b>351</b> | <b>Түүхий эд материал</b>                          | 1,454,750.00         | 40,154,750.00        |
| 35110      | Гусгай зориулалттай материал                       | 1,454,750.00         | 40,154,750.00        |
| <b>354</b> | <b>Хангамжийн материал</b>                         | 3,151,100.00         | 6,177,350.00         |
| 35410      | Бичиг хэргийн материал                             | 350,200.00           | 475,200.00           |
| 35420      | Аж ахуйн материал                                  | 2,360,000.00         | 5,261,250.00         |
| 35430      | Сэлбэг хэрэгсэл                                    | 370,000.00           | 370,000.00           |
| 35470      | Бусад хангамжийн материал                          | 70,900.00            | 70,900.00            |
| <b>2</b>   | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                 | <b>6,692,573.78</b>  | <b>4,322,561.54</b>  |
| <b>39</b>  | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>                              | 6,692,573.78         | 4,322,561.54         |
| <b>392</b> | <b>Биет хөрөнгө</b>                                | 6,692,573.78         | 4,322,561.54         |
| 39203      | Авто-тээврийн хэрэгсэл                             | 30,459,500.00        | 30,459,500.00        |
| 39204      | Хуримтлагдсан элэгдэл                              | -                    | -                    |
| 39205      | Машин тоног төхөөрөмж (компьютер)                  | 29,316,458.40        | 29,969,625.12        |
| 39206      | Хуримтлагдсан элэгдэл                              | 15,194,594.00        | 15,194,594.00        |
| 39207      | Тавилга, аж ахуйн эд хогшил                        | -                    | -                    |
| 39208      | Хуримтлагдсан элэгдэл                              | 13,722,127.36        | 14,061,927.40        |
| 39209      | Тавилга, аж ахуйн эд хогшил                        | 13,770,451.84        | 13,770,451.84        |
| 39210      | Хуримтлагдсан элэгдэл                              | -9,693,386.30        | 11,070,431.78        |
| <b>3</b>   | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                 | <b>11,298,423.78</b> | <b>50,654,661.54</b> |
| <b>4</b>   | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>                              | <b>150,000.00</b>    | <b>00.00</b>         |
| <b>41</b>  | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                   | 150,000.00           | 00.00                |
| <b>413</b> | <b>Өглөг</b>                                       | 150,000.00           | 00.00                |
| 41310      | Ажилчидтай холбогдсон өглөг                        | 150,000.00           | 00.00                |
| <b>5</b>   | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                    | <b>11,148,423.78</b> | <b>50,654,661.54</b> |
| <b>51</b>  | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                 | 11,148,423.78        | 50,654,661.54        |
| <b>512</b> | <b>Хуримтлагдсан үр дүн</b>                        | 11,148,423.78        | 50,654,661.54        |
| 51210      | Өмнөх үеийн үр дүн                                 | 11,148,423.78        | 11,148,423.78        |
| 51220      | Тайлант үеийн үр дүн                               | 00.00                | 39,506,237.76        |
| <b>6</b>   | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b> | <b>11,298,423.78</b> | <b>50,654,661.54</b> |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт                               | Өмнөх оны гүйцэтгэл   | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|-----------------------|-----------------------|
| <b>1</b>   | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (!)</b> | <b>184,657,744.00</b> | <b>230,766,780.00</b> |
| <b>12</b>  | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>             | <b>2,939,544.00</b>   | <b>00.00</b>          |
| <b>120</b> | <b>Нийтлэг татварын бус орлого</b>     | 2,939,544.00          | 00.00                 |
| 120004     | Төсөв байгууллагын өөрийн орлого       | 2,939,544.00          | 00.00                 |
| 1200045    | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого      | 2,939,544.00          | 00.00                 |

|             |  |                       |                       |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>   | <b>181,718,200.00</b> | <b>230,766,780.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>   | 148,776,100.00        | 148,522,800.00        |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт  | 148,776,100.00        | 148,522,800.00        |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | 32,942,100.00         | 82,243,980.00         |
| 131101      | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж  | 29,542,100.00         | 72,333,980.00         |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00                 | 3,000,000.00          |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | 3,400,000.00          | 6,910,000.00          |
| <b>2</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>   | <b>199,519,080.23</b> | <b>191,260,542.24</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>199,519,080.23</b> | <b>191,260,542.24</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | 199,518,680.23        | 191,260,542.24        |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>   | 110,113,800.00        | 119,519,810.92        |
| 210101      | Үндсэн цалин   | 77,573,300.00         | 83,703,441.38         |
| 210102      | Нэмэгдэл   | 18,593,200.00         | 20,712,319.11         |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт  | 13,947,300.00         | 11,604,050.43         |
| 210104      | Урамшуулал   | 00.00                 | 3,500,000.00          |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>  | 14,831,600.00         | 15,617,389.08         |
| 210201      | Тэтгэврийн даатгал   | 10,437,100.00         | 10,950,733.29         |
| 210202      | Тэтгэмжийн даатгал   | 1,098,600.00          | 1,104,696.52          |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал  | 878,900.00            | 1,005,214.80          |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал   | 219,700.00            | 345,446.34            |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал  | 2,197,300.00          | 2,211,298.13          |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>   | 445,500.00            | 357,200.00            |
| 210304      | Байрны түрээс  | 445,500.00            | 357,200.00            |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>  | 30,209,602.00         | 28,933,350.00         |
| 210401      | Бичиг хэрэг  | 3,100,550.00          | 2,447,770.00          |
| 210402      | Тээвэр, шатахуун   | 8,537,000.00          | 16,550,255.00         |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр   | 1,790,350.00          | 1,011,900.00          |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс  | 16,781,702.00         | 8,923,425.00          |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>   | 13,833,000.00         | 2,119,580.00          |
| 210603      | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл   | 00.00                 | 65,650.00             |
| 210604      | Урсгал засвар  | 13,833,000.00         | 2,053,930.00          |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>  | 13,911,600.00         | 16,032,800.00         |
| 210702      | Дотоод албан томилолт  | 13,911,600.00         | 16,032,800.00         |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>  | 10,727,000.00         | 5,960,400.00          |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                       | 10,160,200.00         | 5,484,000.00          |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох   | 148,500.00            | 124,800.00            |
| 210803      | Даатгалын үйлчилгээ  | 69,300.00             | 58,200.00             |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар   | 79,200.00             | 66,600.00             |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо  | 19,800.00             | 16,700.00             |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ  | 250,000.00            | 210,100.00            |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>   | 5,446,578.23          | 2,720,012.24          |

|             |  |                       |                      |
|-------------|--|-----------------------|----------------------|
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                    | 00.00                 | 350,000.00           |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                  | 00.00                 | 00.00                |
| 210903      | Үндсэн хоронгийн элэгдэл, хорогдол                 | 5,446,578.23          | 2,370,012.24         |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                            | <b>400.00</b>         | <b>00.00</b>         |
| <b>2133</b> | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b> | <b>400.00</b>         | <b>00.00</b>         |
| 213303      | Төвлөрүүлэх шилжүүлэг                              | 400.00                | 00.00                |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>          | <b>-14,861,336.23</b> | <b>39,506,237.76</b> |
| <b>5</b>    | <b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>                     | <b>-14,861,336.23</b> | <b>39,506,237.76</b> |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код  | Үзүүлэлт  | Өмнөх оны гүйцэтгэл   | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>         | <b>181,718,200.00</b> | <b>230,766,780.00</b> |
| <b>2</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>          | <b>180,019,200.00</b> | <b>230,766,780.00</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                  | <b>180,019,200.00</b> | <b>230,766,780.00</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                | <b>180,018,800.00</b> | <b>230,766,780.00</b> |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>              | 109,963,800.00        | 120,255,200.00        |
| 210101      | Үндсэн цалин  | 77,323,300.00         | 82,726,400.00         |
| 210102      | Нэмэгдэл  | 18,593,200.00         | 21,881,500.00         |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт                                 | 13,947,300.00         | 12,147,300.00         |
| 210104      | Урамшуулал  | 00.00                 | 3,500,000.00          |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b> | 14,831,600.00         | 15,032,000.00         |
| 210201      | Тэтгэврийн даатгал                                    | 10,437,100.00         | 10,221,700.00         |
| 210202      | Тэтгэмжийн даатгал                                    | 1,098,600.00          | 1,202,600.00          |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал                                     | 878,900.00            | 962,100.00            |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал                                  | 219,700.00            | 240,500.00            |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал                                 | 2,197,300.00          | 2,405,100.00          |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>      | 445,500.00            | 357,200.00            |
| 210304      | Байрны түрээс   | 445,500.00            | 357,200.00            |
| 210305      | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/                      | 00.00                 | 00.00                 |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>               | 25,691,500.00         | 27,465,260.00         |
| 210401      | Бичиг хэрэг   | 2,133,000.00          | 2,877,000.00          |
| 210402      | Тээвэр, шатахуун                                      | 8,084,000.00          | 16,885,980.00         |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                    | 2,370,300.00          | 1,011,900.00          |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс           | 13,104,200.00         | 6,690,380.00          |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>                               | 521,400.00            | 299,600.00            |
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл                           | 521,400.00            | 299,600.00            |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>              | 2,379,200.00          | 33,114,600.00         |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл                               | 00.00                 | 30,585,000.00         |
| 210603      | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл                          | 178,200.00            | 149,800.00            |
| 210604      | Урсгал засвар   | 2,201,000.00          | 2,379,800.00          |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>                         | 15,147,200.00         | 16,032,800.00         |

|             |  |                             |                      |
|-------------|--|-----------------------------|----------------------|
| 210702      | Дотоод албан төмилөлт  | 15,147,200.00               | 16,032,800.00        |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>            | <b>10,727,000.00</b>        | <b>18,116,420.00</b> |
| 210901      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж       | 10,160,200.00               | 17,640,020.00        |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                                   | 148,500.00                  | 124,800.00           |
| 210803      | Даатгалын үйлчилгээ  | 69,300.00                   | 58,200.00            |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар   | 79,200.00                   | 66,600.00            |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо  | 19,800.00                   | 16,700.00            |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ  | 250,000.00                  | 210,100.00           |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                                     | <b>411,600.00</b>           | <b>93,700.00</b>     |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх  | 411,600.00                  | 93,700.00            |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>400.00</b>               | <b>00.00</b>         |
| <b>2133</b> | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                         | <b>400.00</b>               | <b>00.00</b>         |
| 213303      | Төвлөрүүлэх шилжүүлэг  | 400.00                      | 00.00                |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>                    | <b><u>1,699,000.00</u></b>  | <b><u>00.00</u></b>  |
| <b>5</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>                           | <b>1,699,000.00</b>         | <b>00.00</b>         |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>  | <b>1,699,000.00</b>         | <b>00.00</b>         |
| <b>2200</b> | <b>Дотоод эх үүсвэрээр</b>   | <b>1,699,000.00</b>         | <b>00.00</b>         |
| 225106      | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал                             | 1,699,000.00                | 00.00                |
| <b>6</b>    | <b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b> | <b><u>-1,699,000.00</u></b> | <b><u>00.00</u></b>  |
|             | <b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>                           | <b><u>00.00</u></b>         | <b><u>00.00</u></b>  |
| <b>7</b>    | <b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>                     | <b><u>00.00</u></b>         | <b><u>00.00</u></b>  |
| <b>8</b>    | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>                           | <b>00.00</b>                | <b>00.00</b>         |
| <b>9</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>                    | <b>00.00</b>                | <b>00.00</b>         |
| <b>10</b>   | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>                   | <b>00.00</b>                | <b>00.00</b>         |

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт                              | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| C01 | 2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 00.00                           | 00.00                 | 26,009,760.01     | 26,009,760.01                          |
| C08 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 00.00                           | 00.00                 | 11,148,423.78     | 11,148,423.78                          |
| D01 | 2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 00.00                           | 00.00                 | 11,148,423.78     | 11,148,423.78                          |

|     |  |              |              |                      |                      |
|-----|--|--------------|--------------|----------------------|----------------------|
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт   | 00.00        | 00.00        | 00.00                | 00.00                |
| D03 | <b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>            | <b>00.00</b> | <b>00.00</b> | <b>11,148,423.78</b> | <b>11,148,423.78</b> |
| D08 | Тайлант үеийн үр дүн                         | 00.00        | 00.00        | 39,506,237.76        | 39,506,237.76        |
| D09 | <b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b> | <b>00.00</b> | <b>00.00</b> | <b>50,654,661.54</b> | <b>50,654,661.54</b> |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт  | Тайлант оны           |                |
|-----------------------|---|-----------------------|----------------|
|                       |   | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл      |
| <b>2</b>              | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>              | 148,522,800.00        | 148,522,800.00 |
| <b>21</b>             | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                                  | 148,522,800.00        | 148,522,800.00 |
| <b>210</b>            | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                | 148,522,800.00        | 148,522,800.00 |
| <b>2101</b>           | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>              | 120,255,200.00        | 120,255,200.00 |
| 210101                | Үндсэн цалин  | 82,726,400.00         | 82,726,400.00  |
| 210102                | Нэмэгдэл  | 21,881,500.00         | 21,881,500.00  |
| 210103                | Унаа хоолны хөнгөлөлт                                 | 12,147,300.00         | 12,147,300.00  |
| 210104                | Урамшуулал  | 3,500,000.00          | 3,500,000.00   |
| <b>2102</b>           | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b> | 15,032,000.00         | 15,032,000.00  |
| 210201                | Тэтгэврийн даатгал                                    | 10,221,700.00         | 10,221,700.00  |
| 210202                | Тэтгэмжийн даатгал                                    | 1,202,600.00          | 1,202,600.00   |
| 210203                | ҮОМШӨ-ний даатгал                                     | 962,100.00            | 962,100.00     |
| 210204                | Ажилгүйдлийн даатгал                                  | 240,500.00            | 240,500.00     |
| 210205                | Эрүүл мэндийн даатгал                                 | 2,405,100.00          | 2,405,100.00   |
| <b>2103</b>           | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>      | 641,000.00            | 641,000.00     |
| 210304                | Байрны түрээс   | 641,000.00            | 641,000.00     |
| <b>2104</b>           | <b>Хангамж, бараа материалын зардал</b>               | 8,098,500.00          | 8,098,500.00   |
| 210401                | Бичиг хэрэг   | 1,377,000.00          | 1,377,000.00   |
| 210402                | Тээвэр, шатахуун                                      | 3,405,200.00          | 3,405,200.00   |
| 210403                | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                    | 1,011,900.00          | 1,011,900.00   |
| 210406                | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс           | 2,304,400.00          | 2,304,400.00   |
| 210407                | Аж ахуйн материал худалдан авах зардал                | -                     | -              |
| <b>2105</b>           | <b>Нормативт зардал</b>                               | 299,600.00            | 299,600.00     |
| 210503                | Нормын хувцас, зөөлөн эдлэл                           | 299,600.00            | 299,600.00     |
| <b>2106</b>           | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>              | 2,529,600.00          | 2,529,600.00   |
| 210603                | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл                          | 149,800.00            | 149,800.00     |
| 210604                | Урсгал засвар   | 2,379,800.00          | 2,379,800.00   |

|        |   |                |                |
|--------|---|----------------|----------------|
| 2107   | <b>Төмилөлт, зочны зардал</b>                                   | 1,096,800.00   | 1,096,800.00   |
| 210702 | Дотоод албан төмилөлт   | 1,096,800.00   | 1,096,800.00   |
| 2108   | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b> | 476,400.00     | 476,400.00     |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                        | 124,800.00     | 124,800.00     |
| 210803 | Даатгалын үйлчилгээ   | 58,200.00      | 58,200.00      |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар                                      | 66,600.00      | 66,600.00      |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо                                   | 16,700.00      | 16,700.00      |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                 | 210,100.00     | 210,100.00     |
| 2109   | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                          | 93,700.00      | 93,700.00      |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                               | 93,700.00      | 93,700.00      |
|        | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                           | 148,522,800.00 | 148,522,800.00 |
| 1310   | <b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                  | 148,522,800.00 | 148,522,800.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих   | 148,522,800.00 | 148,522,800.00 |
| 4      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>         | -              | -              |
| 5      | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>        | -              | -              |
| 6      | <b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>                         | -              | -              |
| 61     | <b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>   | -              | -              |
| 62     | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>   | 9.00           | 9.00           |
| 620001 | Удирдах ажилтан   | 1.00           | 1.00           |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан   | 7.00           | 7.00           |
| 620003 | Үйлчлэх ажилтан   | 1.00           | 1.00           |
| 620004 | Гэрээт ажилтан  | -              | -              |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт                                    | Гүйцэтгэл            |
|------------|---|----------------------|
| I          | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>    | <b>82,243,980.00</b> |
| 21         | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                        | <b>82,243,980.00</b> |
| 210        | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>      | 82,243,980.00        |
| 2104       | <b>Хангамж, бараа материалын зардал</b>     | 19,082,960.00        |
| 210401     | Бичиг хэрэг                                 | 1,500,000.00         |
| 210402     | Тээвэр, шатахуун                            | 13,196,980.00        |
| 210406     | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,385,980.00         |
| 2106       | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>    | 30,585,000.00        |

|             |  |                      |
|-------------|--|----------------------|
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл  | 30,585,000.00        |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>  | <b>14,936,000.00</b> |
| 210702      | Дотоод албан томилолт  | 14,936,000.00        |
| 210703      | Зочин төлөөлөгч хүлээн авах  | 00.00                |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>  | <b>17,640,020.00</b> |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                       | 17,640,020.00        |
| <b>II</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>  | <b>82,243,980.00</b> |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | <b>82,243,980.00</b> |
| 131101      | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж  | 72,333,960.00        |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,000,000.00         |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | 6,910,000.00         |
| 131106      | Төсвийн урамшуулал   | 00.00                |

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хар нуур ховд голын сав газрын захиргаа нь Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон усны зохистой ашиглалт хамгаалалтыг бий болгох замаар сав газрын нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах эрхэм зорилгын дор Усны нөөцийг зохистой ашиглах хамгаалах нөхөн сэргээх замаар эко системийн тэнцвэрт байдлыг хамгаалах усны тухай хууль, Ус үндэсний хөтөлбөр зэрэг төрөөс усны талаар баримталж буй бодлогын хэрэгжилтийг сав газрын түвшинд орон нутагт хангахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх үндсэн чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

БОАЖЯ-ны сайдын 2018 оны 05 дугаар сарын 30-ний өдрийн А/158 тоот тушаалаар Хар нуур ховд голын сав газрын захиргааг 9 орон тоотой байхаар баталсан байна. Удирдах 1 гүйцэтгэх 7, үйлчилгээний 1 нийт 9 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдаж хэрэгжиж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага Байгаль орчны тухай хууль, Усны тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын даргын 2020 оны А/18 тушаалаар байгуулагдсан өмч хамгаалах зөвлөл тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна. Тайлант онд дотоод аудит, хяналт, шинжилгээ үнэлгээний газраас хяналт шалгалт хийгдээгүй байна.

Тайлант онд Хар нуур ховд голын сав газрын захиргаа нь 2022 оны 11 дугаар сарын 15-ны А/18 дугаар тушаалаар байгууллагын тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 3 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хар нуур ховд голын сав газрын захиргаа нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хар нуур ховд голын сав газрын захиргааны 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 39.3 сая төгрөгөөр буюу 3 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| /мянган төгрөгөөр/                           |                     |                     |                     |
|--|---------------------|---------------------|---------------------|
| Үзүүлэлт                                     | Эхний үлдэгдэл      | Эцсийн үлдэгдэл     | Өөрчлөлт            |
| Б  | 1                   | 2                   | 3=2-1               |
| Бараа материал                               | 4,605,850.0         | 46,332,100.0        | 41,726,250.0        |
| Үндсэн хөрөн ө                               | 6,692,573.8         | 4,322,561.5         | (2,370,012.2)       |
| <b>Нийт хөрөнгө</b>                          | <b>11,298,423.8</b> | <b>50,654,661.5</b> | <b>39,356,237.8</b> |
| Өр төлбөр                                    | 150,000.0           | -                   | (150,000.0)         |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/     | 11,148,423.8        | 50,654,661.5        | 39,506,237.8        |
| <b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b> | <b>11,298,423.8</b> | <b>50,654,661.5</b> | <b>39,356,237.8</b> |

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ *Бараа материал 41726.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь дэлхийн байгаль хамгаалах сангийн төслийн хөрөнгөөр Буянт голын дагуу хяналтын камержуулалтын багаж дагалдах хэрэгслийг тусгай зориулалтай материалын дансанд тусгасантай холбоотой байна.*
- ✓ *Нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 39356.3 мянган төгрөгөөр, засгийн газрын хувь оролцоо 39506,3 мянган төгрөгөөр тус тус өссөн нь бараа материалын орлого нэмэгдсэн холбоотой байна.*

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 148,522.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 148,522.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 148,522.8 мянган төгрөг буюу 100 хувьтай зарцуулсан байна.

#### **Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл**

| /мянган төгрөгөөр/ |                       |                  |                  |          |             |
|--------------------|-----------------------|------------------|------------------|----------|-------------|
| д/д                | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө       | Гүйцэтгэл        | Зөрүү    | Биелэлт     |
| 1                  | 71404/80101-Зардал    | 148,522.8        | 148,522.8        | -        | 100%        |
|                    | <b>ДҮН</b>            | <b>148,522.8</b> | <b>148,522.8</b> | <b>-</b> | <b>100%</b> |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Дэлхийн байгуулах хамгаалах сангаас 72,333.3 мянган төгрөг, дээд шатны байгууллагаас 3,000.0 мянган төгрөг, Төсөвт байгууллагын үйл ажиллагааны нэмэлт орлогоос 6,910.0 мянган төгрөг нийт 82,243.9 сая төгрөг бүрдүүлж Буянт голын дагуу камержуулалтын ажил болон томилт, тээвэр шатахуун, сургалтын зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мал эмнэлгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн орлогын гүйцэтгэл, хөрөнгө, бараа материалтай холбоотой зөвлөмж тусгасан.

Аудитыг аудитор С.Оюунжаргал 2023 оны 02 дугаар сарын 14-ны өдрөөс 02 дугаар сарын 16-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 13 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 191.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 2.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2.3 сая төгрөгөөр тогтоосон

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон дараах зардлуудыг санхүүжүүлсэн байна.

*4.3.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйл зөрчиж байгууллагын төсвөөс албан хаагчдад спортын хувцасны зардалд 1525.1 сая төгрөг зарцуулсан.*

*12 дугаар зүйл зөрчиж байгууллагын төсвөөс 499.0 мянган төгрөгийн хоолны зардал төлсөн байна.*

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд таван саяас дээш орлогын гүйлгээг бүрэн мэдээлж, зарлагын гүйлгээ, төсөв өмч хөрөнгөтэй холбоотой 7 мэдээлэл мэдээлээгүй байсныг аудитын явцад залруулан мэдээлүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгөгдсөн 150.0 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгөгдсөнөөс бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт |       | Биелэлт |       |       |
|----------|------------------------|-------|---------|-------|-------|
|          | Тоо                    | Дүн   | Тоо     | Дүн   | Хувь  |
| Зөвлөмж  | 1                      | 150.0 | 1       | 150.0 | 100.0 |
| Нийт дүн | 1                      | 150.0 | 1       | 150.0 | 100   |

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар БОАЖЯ-наас ирсэн А-79 маркын авто машиныг орлогод аваагүй байгааг анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар Шилэн дансны цахим системд таван саяас дээш орлогын гүйлгээг бүрэн мэдээлж, 3 зарлагын гүйлгээ, төсөв өмч хөрөнгөтэй холбоотой 7 мэдээлэл мэдээлээгүй байсныг аудитын явцад залруулан мэдээлүүллээ.

Аудитаар нийт 3.9 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 2.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож 1.9 сая төгрөгийн 1 зөвлөмж өгөв.

#### 5.1 Төлбөрийн акт

- ✓ Байгууллагын төсвөөс 499.0 мянган төгрөгийн хоолны мөнгө, 1525.1 сая төгрөгийн Албан хаагчдад спортын хувцас авсан зөрчлүүд илэрлээ энэ нь төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4.хуулиар зөвшөөрөөгүй бусад, 8 дугаар зүйлийн 8.1"Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## 5.2 Зөвлөмж

### 5.2.1 Цалин хөлстэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Албан хаагчдад 1996.7 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлсийг норматив хэмжээнээс хэтрүүлэн олгосон зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" МУ-ын засгийн газрын 382 тоот тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дахь заалт "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна" гэсэн заалтуудыг зөрчсөн, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж :** Байгууллагын ажилтан албан хаагчид илүү цагийн нэмэгдэл хөлс олгохдоо засгийн газрын тогтоол баримталж олгох

### 5.2.2 Үндсэн хөрөнгөтэй холбоотой

**Илрүүлэлт:** "БОАЖЯ-наас үнэ төлбөргүй ирсэн А-79 маркын авто машиныг төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоол шийдвэр гараагүй шалтгаанаар хөрөнгөд аваагүй байгууллагын үйл ажиллагаанд ашиглаж байгаа Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", "УСНББОУС-1, АДБОУС 1250, 1300, MNS-6817-4:2020 стандартын 7.1.2.2, 7.1.3.4 заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж :** Үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийн тооллого хийж бүртгээлгүй хөрөнгөөр бүртгэж баталгаажуулах, элэгдлийн хэрхэн тооцох талаар шийдвэр гаргуулах, хөрөнгөд тавих дотоод хяналтыг сайжруулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | Мэдээллийг тусгахгүй | Буруу тусган | Үүнээс     |              | Зөвлөмж |  |
|-------------------|------------|----------------------|--------------|------------|--------------|---------|--|
|                   |            |                      |              | Залруулсан | Залруулаагүй |         |  |
|                   |            |                      |              |            |              |         |  |

|   |     |     | орхигдуулсан |     | илэрхийлсэн |     |     |     |     |     |   |   |
|---|-----|-----|--------------|-----|-------------|-----|-----|-----|-----|-----|---|---|
|   | Тоо | Дүн | Тоо          | Дүн | Тоо         | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |   |   |
| Шилэн дансны нэгдсэн системд 5 сая төгрөгөөс дээш үний дүн бүхий зарлагын 3 гүйлгээ, төсөв өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой 7 мэдээлэл оруулаагүй | 1.0 | -   | 1.0          | -   | -           | -   | 1.0 | -   | -   | -   | - | - |
| Дүн   | 1.0 | -   | 1.0          | -   | -           | -   | 1.0 | -   | -   | -   | - | - |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр

| Зөрчлийн товч утга                                       | Нийт зөрчил |         | Үүнээс        |         |                 |     |         |     |
|--|-------------|---------|---------------|---------|-----------------|-----|---------|-----|
|  |             |         | Төлбөрийн акт |         | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|  | Тоо         | Дүн     | Тоо           | Дүн     | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил |             |         |               |         |                 |     |         |     |
| Алдаа илрээгүй   |             | -       | -             | -       | -               | -   | -       | -   |
| Дүн  |             |         |               |         |                 |     |         |     |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил                 |             |         |               |         |                 |     |         |     |
| байгууллагын төсвөөс спортын хувцас, хоолны мөнгө төлсөн | 1.0         | 2,024.1 | 1.0           | 2,024.1 | -               | -   | -       | -   |
| Дүн  |             |         |               |         |                 |     |         |     |
| Нийт дүн   |             |         |               |         |                 |     |         |     |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЯДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:  С.ОЮУНЖАРГАЛ